



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 02

Арвайхээр

Цэвэр усны хангамжийг жигдрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "л" заалт, Засгийн газрын 2018 оны "Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 220 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Арвайхээр сумын цэвэр усны хангамжийг жигдрүүлэх талаар ДААЛГАХ нь:

1. Арвайхээр сумын Засаг дарга, "Онги-Ус суваг" ОНӨААТҮГазарт

1.1. "Онги ус суваг"-ийн нөөцийн гүний хоёрдугаар худгийн 380вт-ын шугмын найдвартай байдлыг хангах, цахилгааны монтажийг сэлгэн залгалттай болгож хэвийн ажиллагаанд оруулах

1.2. Онги голын төслөөр хийгдсэн Арвайхээр сумын цэвэр усны эх үүсвэрийн гүний худгийн цахилгааны эх үүсвэрийг нөөц үүсвэртэй болгох талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран шийдвэрлэх, оновчтой шийдэл гаргуулж төсвийн тооцоог хийж ирүүлэх

Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг 7 дугаар сарын 31-ний дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлэхийг Арвайхээр сумын Засаг дарга (О.Пүрэвдорж), "Онги-Ус суваг" ОНӨААТҮГазрын захирал (О.Лхагвасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

123000003